



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

15100 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Б.Шэрэгдэвийн гудамж 8/4, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, И-мэйл: info@mojha.gov.mn,
Вэбсайт: www.mojha.gov.mn

2021.05.25 № 1/2410
танай 2021.05.25 № 12-Т

ДУНДГОВЬ АЙМГИЙН ДЭЛГЭРЦОГТ
СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА П.ТҮВШИНСАЙХАН
ТАНАА

Танай сумын иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн
"Малын тоо толгойд албан татварын хувь хэмжээ
тогтоох тухай" 11 дүгээр тогтоолыг Захиргааны
ерөнхий хуулийн дагуу хянан үзээд Захиргааны хэм
хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн
5269... дугаарт бүртгэснийг үүгээр мэдэгдье.

ДЭД САЙД

С.БААТАРЖАВ



15131197/
2021.05.25



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 11

Амгалант

Малын тоо толгойд албан татварын
хувь хэмжээ тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "г" "д" заалт, 25 дугаар зүйлийн 25.1, Малын тоо толгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 6.3 6.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас ТОГТООХ НЬ:

Нэг. Дэлгэрцогт сумын хэмжээнд нэг малын тоо толгойд ноогдуулах татварын хувь хэмжээг дор дурьдсанаар тогтоосугай.

1. Тэмээ 0
2. Адуу 1000
3. Үхэр 1000
4. Хонь 400
5. Ямаа 500

Хоёр. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөнд хамрагдах өрхийг БИНХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлэж, сумын малын тоо толгойн татварын орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж ажиллахыг Сумын Засаг дарга /М.Баярсүх/-д даалгасугай.

ДАРГА



П.ТҮВШИНСАЙХАН